

ОНЛАЙН ОЛИМПИАДЫН ХУВЦАСНЫ ДИЗАЙНЫ ТӨРӨЛД ДАРААХ ЗҮЙЛСИЙГ БЭЛТГЭХ

1. Олимпиадын байрны орчин

Ширээний орчин хангалттай гэрэлтүүлэгтэй орчинг сонгосон байна. Орчин буюу зурж гүйцэтгэх явцыг бичих утасыг камерийн өнцөгийг зөв харагдаж байхаар (утасны ар талын камер байх) Селфи гар ашиглан байрлуулсан байна. Хэрвээ гар байхгүй тохиодолд босоо байрлалтай зүйлсэд утасаа бэхэлнэ.

Анхаарах зүйлс:

- Утасны бичлэгийг даалгавар гүйцэтгэж эхэлснээс хойш дуусах хугацаа хүртэл бичнэ. Ширээн дээр бүх хэрэгслийг бэлтгэн тавьсан байх ба утасны бичлэгээ өөрийн ажиллах хэсгийг ерөнхийд нь харагдаж байхаар байрлуулж, түүний хүрээнээс 5 минутаас илүү холдохгүй байна.
- Сэдвийн дагуу эскиз боловсруулах /A4 формат/, боловсруулсан эскизийн дагуу өөрийн хэмжээн дээр эсгэж, хувцасаа гараар болон оёдлын машинаар оёж гүйцэтгэнэ.
- Бэлэн болсон хувцасаа өөрөө өмсөж зураг авхуулах, хувцасны нарийн деталь хэсгүүдийн зургийг авсан байх.
- Даалгаварын эскиз боловсруулалтын зургийг авахдаа эгц харуулсан чиглэлээр нэмэлт гэрэл тусгаж (спичка асаахгүйгээр) авсан байна.

2. Хэрэглэгдэх материал

- Хаягдал төрөл бүрийн материал / хаягдал хувцас, даавууны өөдөс, цаас, сонин, сэтгүүл гэх мэт.../
- Будгийн хэрэгсэлүүд / гуаш, усан будаг, өнгийн харандаа гэх мэт.../
- Оёдлын хэрэгсэл / утас, зүү, хайч, шугам, метр, эсгүүрийн шохой, оёдлын машин бэлтгэх/
- A4 цаас 4-5 ш
- Компьютер (Зурж гүйцэтгэсэн ажлынхаа талаар тайлбар хуудас бичих зориулалттай)

3. Даалгавар илгээхэд анхаарах зүйлс:

- Гүйцэтгэсэн даалгавар ажлынхаа зургийг авч jpg өргөтөлөөр илгээнэ.
- Мөн даалгавартай холбоотой тайлбар, бичгийг PDF өргөтгөлөөр илгээнэ. Үүнд:
 - a. Гүйцэтгэсэн хүний хаяг, утас
 - b. Даалгавар гүйцэтгэсэн талаарх тайлбар
 - c. Даалгавар гүйцэтгэхэд ашигласан ном, материал, цахим хаягийн жагсаалт байна.